

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



УЛС ТӨР

НЭЙЛ САКЕР: “САНХҮҮГИЙН ӨРГӨТГӨСӨН ХӨТӨЛБӨР”-ИЙГ ОЙРЫН ХУГАЦААНД БАТАЛНА

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

МОД ТАРЬЖ, БУЯН ҮЙЛДЭЖ ЧАДСАН УУ

V нүүрт

Дугаарын **60** мөр

Сумын төвд хүн амьдрах арга алга

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улс нэг үеэз бодвол хөгжих байгаа. Тэр дундаа Улаанбаатар хот одроос өдөрт л онголог болж, өөдөлж, дээшилж байна. Муу муухай зүйл их бий. Гэхдээ сайн сайхан нь ч бас бий. Тийм болоо ор энэ удаад сайнгын эхэлийг дурьдаж буй хэрэг. Эргэн тойронд байгаа гэр хорооллыг эс тооцвортайсилэл нээрээ гайгүй узэмжтэй болчихсон шуу. Харин хөдөө, орон нутагт өөдөлж, дээшилж байгаа зүйл маруухан байна. Тэр дундаа сумдад хүн амьдрах боломж нохцэл үнэхээр алга байна. Нэдүүгээр, тэнд хийх ажил байхгүй. Торийн хэдэн байгууллагад нь л ажиллаж чадвал их юм. Өөрөөр бол, хэдүүхэн. За тэгээд амьдрах орчин бол үнэхээр хэцүүхэн.

Үргэлжлэл нь III нүүрт

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

САЙДАА УЛ ТООЖ, “ХОНХНЫ БАЯР”-ЫГ НУУЦ ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЖЭЭ



Н.БАТЗАЯА

Хаврын сүүл сар гарч, сүүлчийн

хонхны жингэнэх чимээн дуу одор өдрөөр ойртоор л... Дөнгөж авран жилийн сургуулийн ахлах

ангиа төгсож, амьдрал гэх их дэлдэй хөл тавихаар яарах хүүхдүүд “сүүлчийн хичээлийн одор”-ийг

Гэрээ зүйлийн Г.АРГУУЖИН

инээд хоор, баяр баяслаар дүүрэн сэтгэл додлон хүлээж буй.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

МАН
Ерөнхийлөгчид
нэр дэвшигчээ
өнөөдөр
тодруулна

Б.СУМЬЯА

МАН-ын Бага хурал өнөөдөр болохоор товлогдсон. Тус нам бага хурлаараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдхөн нэр дэвшигчээ тодруулахаар төлөвлөөд байгаа аж. Бага хурал нь 300 гаруй гишүүнтэй. МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдхөн нэр дэвшигчийг судалгаанд үндэслэн Бага хуралд оруулж ирж, санал хураалгана гэдгээ онгорсөн долоо хоногт мэдэгдсэн. Иймээс МАН-ас Ерөнхийлөгчид гурван хүн нэр дэвшиж, сунгаанд өрсөлдхөн болов уу гэсэн урьдчилсан таамаг гараад байна.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

АН-ААС ЕРӨНХИЙЛӨГЧИД НЭР ДЭВШИХ ХҮСЭЛТЭЙ УЛСТӨРЧИД БҮРТГҮҮЛЛЭЭ


-АН-ын нийт гишүүдийн олонхийн санал авсан хүнийг энэ сарын Об-нд болох намын VIII Их хурлаар баталгаажуулна-

ДОТОР НҮҮРТ



МОНГОЛ БРЭНД
“MANDU HOUSE”-Д ЗОЧЛООРОЙ

8



ҮЗЭЛ БОДОЛ

Ипотекийн зээлийг “АРЫН ХААЛГААР” л авдаг болсон гэнэ үү

Н.ПУНЦАГБОЛД

Тохилог байранд амьдарч, тав тухтай байхыг бодлогтуу хүн гэж юу байх вэ. Өнөөдөр Улаанбаатар хотын гэр хорооллыг бүрдүүлж буй 200 гаруй мянган орхийн ихэнх нь орон сууцанд орохыг хүчэ байгаа нь ойлгомжтой. Ингээд бодохоор орон сууцны эрэлт хэрэгцээ огтуулж ипотекийн найман хувийн хүүтэй зээлийг гаргасан.

Гэхдээ үнэ нь хадчихсан байрыг дийлж авах хүн цөөн байна. Тэр дундаа бэлэн монгө гаргаад, 70, 80 саян үнэтэй байр авах хүн угаасаа байхгүй. Түүгээр ч барахгүй, 30 сая тогrog бэлэн гаргаад ч байр авчих хүн байхгүй шүү дээ. Уг нь төр засгаас бага, дунд орлоготой иргэдийг орон сууцжуулахад зориулж ипотекийн найман хувийн хүүтэй зээлийг гаргасан.

Үргэлжлэл нь III нүүрт




Гэрээ зүйлийн Г.АРГУУЖИН

Э.ТУУЛ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтыг 2017 оны зургадугаар сарын 26-ны өдөр явуулахаар УИХ-ын чуулганаас баталсан билээ. Тэгвэл Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвших хүсэлтэй улстөрчид очигдэр 09:00-13:40 цагийн хооронд бүртгүүлж, үнэмлэхээ гардан авлаа. Тодруулбал, УИХ-ын гишүүн Л.Болд, гишүүн асан Р.Амаржаргал, Х.Баттулга, Н.Алтанхуяг, Хууль зүйн сайд асан Дорлигжав болон Б.Жаргалсайхан нар намын дотоод сунгаанд өрсөлдөх бүртгүүлээ. Харин Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх хүсэлтэй байгаагаа мэдэгдэж байсан нийслэлийн Засаг дарга асан Э.Бат-Үүл, нийтлэлч

Баабар нар бүртгүүлсэнгүй. АН-ын нэр дэвшигчийн бүртэл очигдэр 13:40 цагт дууссан багаад Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх хүнэйг АН-ын нийт гишүүдийн олонхийн саналаар тодруулж, энэ сарын 06-нд болох намын VIII Их хурлаар баталгаажуулна. Очигдэр явагдсан бүртгэлийн уеэр АН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Туваан “Сонгуулийн тухай хуулийн дагуу намаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчээ тодруулах хуулийн хугацаа онөөдөр /2017.05.02/ эхлэж байна. Энэ хүрээнд АН-ын үндсэн дүрмийн дагуу намын дарга намын их хурал руу намын гишүүдийн саналд үндэслэн нэр дэвшигчийн нэрийг оруулж өгөх заалттай.

Үргэлжлэл нь II нүүрт



Худалдаа хөгжлийн банк

ХААН банк

	Авах	Зарах	Авах	Зарах	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2410.00	2426.00	ФУНТ	3071.00	3151.00	АМ.ДОЛЛАР	2414.00	2426.00
ЕВРО	2600.00	2669.00	РУБЛЬ	41.40	43.50	ЕВРО	2603.00	2669.00
ИЕН	21.46	21.77	ЮАНЬ	348.30	351.40	ИЕН	21.33	21.90

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙГ “АРЫН ХААЛГААР” Л АВДАГ БОЛСОН ГЭНЭ ҮҮ

Үргэлжлэл.
Түүрүүч нь I нүүрт

Мэдээж улс орон мөнгөгүй учраас хэцүү гэж тайлбарлах байх. Гэхдээ сайд нарынхам багцад нэмчихэж багаа мөнгөнөөсөө хэдийг нь ипотек рүү оруулчихыг язсан сэргэл байвал болно. Одоо бол ипотекийн зээлд өгсөн 4091.2 тэрбум төгрөгийн эргэн төлөлтөөр л хотолборроо санхүүжүүж байгаа. Энэ мөнгөний 77 хувь нь буюу 3.1 их паяд нь хотолбөрийн зээлийн. Үүнээс эргэн төлөлтөөр дунджаара 25 орчин тэрбум төгрөг л орж ирж байгаа. Тухайлбал, 2017 оны хөёрдугаар сард Монголбанкнаас 24.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийн ипотекийн зээлд олгосон. Харин гуравдугаар сард 27.1 тэрбум төгрөгийг гаргасан талаар Монголбанк мэдээлжээ. 24.2 тэрбумаар 396 зээлдэгчийн асуудлыг шийдсэн бол 27.1 тэрбумаар 460 хүнд ипотекийн зээл олгосон байсан. Эрэлтийнхээ дэргэд оччүүхэн тоо л доо. Ядах байхад Монголбанк сардаа огч буй мөнгөө арилжааны 14 банкинд хуваах олгож байгаа. Гэхдээ яг тэндүү биш л дээ, эхлээд ямар хэмжээний зээл огч байсан ба гэдгээсээ хамаараад ялгажтай. Гэхдээ л нэг банкнад хамгийн ихдээ 100 хүний асуудлыг шийдэх л монгө оногдж байгаа бол их юм. Бүр зарим нь 20, 30 хүний л зээлийн хүсэлтийг шийдвэрлэх хэмжээний эх үүсвэрэвч байгаа шүү дээ. Үүнээс шалтгаалаад ипотекийн зээл авна гэдэг “дайн” болж хувирлаа. Ипотекийн зээлэнд хамрагдах хүмүүсийн хүсэлт хэт их ирээд, бөөгнөрчихсон. Тийм болохоор шинээр хүсэлт авах ямар ч аргагүй болсон талаар арилжааны банкууд мэдээлж байна билээ. Нэг таалдаа тийм зөвлөн байгаа. Ногоо талдаа арилжааны банкууд хэт ондёр шалтуур тавьж байгаа. Тухайн банкнаас зээл авсан барилгын компанийн орон сууцыг авбал зээл огно гэсэн тулгат хийж байна хэмжээн иргэд гомдоллох болсон. Тэглээ гээд яах билээ, арилжааны банкууд зээлээ огч байгаа нь унэн. Тийм болохоор дүрэм журам зорчоогүй. Тэгээд ч ипотекийн зээлийн журмын дагуу зээлээ огч байгаа болохор аргагүй. Гэвч орон сууцтай болох гэсэн иргэд аргаабарж байна.Өөрийнхөө хүссэн байрлалд ч орон сууц авах боломжгүй. Ногоо огоч хүн гэдийж, авах хүн бөхийн гэдэг шиг л болсон. Сүүлийн үед ипотекийн зээл авахад “арын хаалга” шаардлагатай болж эхэлсэн талаар иргэд гомдол мэдуулж эхэллээ. Банкнад танил талтай бол зээлийн хүсэлтээ хээээ ч өгсөн шаардлага

хангахаар бол авчихаж болж байгаа юм байх.Өөр нэг арга байгаа нь зээлийн эдийн засагчийг “найрах”. Тодорхой хэмжээнд хувь отье энэ тэр гэж байж зээлээ бүтээдэг болсон гээд ээ. Ийм асуудалтай тулгарч буй иргэд цөөнгүй байна, гадуур. Мэдээж ипотекийн зээлийн санхүүжилт нь бага. Сардаа хэдхэн хүний л асуудлыг шийдэж байгаа. Тэгээд нэг банкнад цөөн хэдхэн төгрөг очиж байгаа болохоор бүр хэцүү. Нохцол байдал нь ийм болохоор дагаад янз бүрийн асуудал үүсж нь тодорхой. Одоо бүр сардаа арилжааны банкуудад огч байгаа хэдэн төгрөгийн 25 хувийг хөдөө, орон нутгийн хэрэглэгчдэд өгсөн байх чиглэлийг Монголбанкнаас өгсөн. Сард дунджаара 25 тэрбум төгрөг ипотекийн зээлд зориулж гаргасан гэж бодоход зургаан тэрбум гаруй нь хөдөө рүү явах нь. Эсвэл хөдөөгийн иргэдэд өгнө гэсэн угл дээ.

Ингээд сардаа 400 хүний асуудлыг шийддэг байсан бол 300 руу орох болох нь. Ингээд ирэхээр ипотекийн зээл авах гэсэн иргэдийн хүсэлт улам л бөгөнөрөн. Цаашлаад танил тал харах, хувь энэ тэр өгөх байдал ч нэмэгдэх болчихоод байна. Ядаж байхад ойрын үед орон сууцны зээлд оруулахаа мөнгө Засгийн газарт байгүй. ОУВС-гийн хотолборт энэ сардаа багтаад хамрагдаж чадвал дагаад олон улсаас зээл авах боломж бүрдэнэ.Хятадаас тэрбум амдоллын зээлийн тодорхой хэсгийг орон сууцжуулах, дахин төловлюлтэд ашиглах талаар мэдээлэл гарсан. Түүнээс өөрөөр орон сууцтай холбоотойгоор мөнгө төгрөг зарцуулах талаар дөрвийт мэдээлэл гаргаагүй байна. Тэр дундаа ипотекийн зээлийн идэвхжүүлэх тал дээр хөрөнгө мөнгө нэмнэ гэсэн мэдээлэл алга. Орон сууц нэмж барина, дахин төловлюлт хийж гээдл байгаа болохоос. Гэтэл зах зээл дээр 40-50 мянган айлын орон сууц бараг л 100 хувь бэлэн болчихсон байгаа гэсэн ерөнхий тоо явад байгаа. Энэ олон орон сууцыг борлуулах тал дээр барилгын компаниуд, төрийн зүгээс дорвийт ажил хийж цаг нь болсон юм биш үү. Тэгэхгүй бол ипотекийн зээлийн хотолбөрийг үлгэн салган явуулж, иргэд нь банкны шалтуур, зээлийн эдийн засагч хөөрьн нь давахгүй зөвсөөр л сууна. Аргаа ядахдаа танил тал хийж, олдохгүй бол гэр хороололдоо л үлдэх болчихоод байгаа юм. Тийм болохоор энэ хотолбөрийг арай боловсронгуй болгох, дөрвийт урагшлуулах тал дээр зөв бодлого гаргах хэрэгтэй байна.

Үргэлжлэл.
Түүрүүч нь I нүүрт

Яах вэ, зарим нэг сум арай дээр байгаа. Сумынхаа төвдөө цөөн хэдэн км хувилттай замтай. Бага ч болв гэрэлтүүлгүй. Харин ихэнх суманд хатуу хувилттай зам байхгүй. Тиймдээ ч сумын төвөөр нь, эргэн тойрон дүүрэн зам. Машинтай болгон хая дуртай газраараа явна, давхилдана. Тэгээд л сумынхаа төвийн бүхий л хөрсийг орвонгоор нь эргүүлчихэн. Хөрс эвдрээд ирэхээр овс ногог ургахгүй. Ядаж байхад манайхан сумын төвдөө мод тарьж, ногоон байгууламж байгуулах биш. Ингээд, л цөлжөөд, жаахан салхи босохоор л улаан широю нудээд, хэцүү гэж. Одоо бүр хангийн сумд хүртэл ийм болгихлоо. Ойролцоо улсынхаа модыг тайраад дууссан. Тэгээд сумын төвөөсөө жаахан зайдуу газарт бол эвс ногоо гайгүйтэй, широю тавихгүй. Гэтэл сумын төвдөө улаан широю тавиад, нүүр нудгүй шуураад байх жишээтэй. Ийм бол хувирчихад байна. Өноөдөр монголчуудын тал нь Улаанбаатар хотод шавчихсан, зам дээрээ түгжрээд, энд тэндгүй дугаарлаж зогсоод, хамаг цаг заваа үзээд байна гэж шүүмжилдэг. Тийм ээ, үнэн. Яг тийм байгаа. Гэхдээ үүнээс өөр арга бидн бий үү. Хаана гайгүй орчин байна, Улаанбаатар. Нийслэлд ганцхан цэвэр цэргэг агаар л дутагдаад байгаа болохос биш бусад бүх зүйл бий. Ажил төрөл ч одлох нь дээр. Ядаж наймаа хийж, гуанз ажиллуулсан ч эдийн засагч эргэлт сайтай. Гэтэл суманд юу байгаа юм. Ядаж олингийт интернат ч алга. Сумын төв хэсэгтээ ч хүний гутал широю болчихоогүй алхах газар байхгүй. Үзвэр үйлилгээ гэж алга. Ахнухан хэдэн хүн очвол сумын төвийн АТМ-ын мөнгө нь дуучихнаа. Хөрс нь эвдрэлтэй, цөлжсон. Шороо шуурсан л газрууд байна.

Тийм газарт хүн амьдрах сонирхолтой байх уу. Үгүй шүү дээ. Ямар ч амьдрах орчин нохцелгүй газарт хэн амьдрахын хүсэх юм. Тийм болохор сумдын удирдлагууд иргэдийг татах, олон хүнтэй болж ажлыг хийж хэрэгтэй. Ядаж ажлын байр гаргаж чадагчтүү юм гэхдээ хүний амьдрах тав тухтай орчинг хангах талын бүхий л ажлыг чадынхан хэрээр хийж гээгүй шүү дээ. Ядаж л сумын төвдөө ногоон байгууламжтай болчихмоор байна.Хатуу хувилттай зам тавьж чадахгүй юм аа гэхдээ шүү. Мэдээж зам тавих тийм амар биш. Өртөг ондөртэй. Харин сумын төвдөө мод тариад, ногоон байгууламжтай болоод, цөлжилтөөс сэргэлжэх бол айхтар үз ортош шаардах ажил биш. Хамгийн гол нь үйлгүй хөдөлмөр л шаардах байх. За тэгээд, хангай газар бол ус дутна гэж биш мод ургуулж уг нь болно доо. Ядаж л энэ мэтийн ажлыг хийжээд, сумын нутгаас өөд нь татаад байна аа. Тэгэхгүй бол суманд хүн амьдрах, тогтох арга үнэндээ л алга байна шүү.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ

Хугацаанд батална

ОУВС яагаад дэмжихгүй байна вэ?

-Монгол Улсын тодорхой нэг компанийтай байгуулсан гэрээний талаар бид байр суурин илэрхийлэх боломжтой. УИХ-ын тогтоод тусгасан заалттай холбоотойгоор Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин гадаадын хөрөнгө оруулах нөхцөлийн бүрдүүлсэн байх ёстой. Энэ нь эргээд Монгол Улсын хөгжил, эдийн засгийн осолтойд зэрэгээр нөлөөлно. Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтыг татах чадвартай сайн орчинтой болно гэдэгт итгэлтэй байна.

-Татвар эмзэг бүлгийнхэнд биш чинээлэг давхаргад чиглэгдсэн гэдгийт тэхэлээ. Гэхдээ Монгол Улс асар их уул уурхайн бүтээгдэхүүн экспортолж байгаа мөртэю бага татвар авч байна. Тухайлбал алтны татварыг нэмэдүүлэх талаар гишүүд санал гаргаж байсан. Энэ асуудлыг хэлэлцэн үү?

-Алтны татварыг нэмэг-

дүүлэхээр алт олборлогчид татвараас зайлсхийх, орлого нуун дарагдуулах асуудал онгорсон хугацаанд гарсан. Алт олборлогчид татварын орчинг дэлхийн жишигт орсолдохуйц түвшинд тогтоосноор алт олборлогчид оөрсдийн үйлдвэрээл, орлогын хэмжээг үзэн зөв шударгаар мэдээлнэ. Үүнийг дунд нооц ашиглсаны Засгийн газарт төвлөрч буй орлогын хэмжээ сүүлийн үед нэмэгдсэн. Сүүлийн саруудад Монголын экспортодлог эрдэс багийг үзэж дэлхийн заалттай талаар иргэд гомдол мэдуулж эхэллээ. Банкнад танил талтай бол зээлийн хүсэлтээ хээээ ч өгсөн шаардлага

“Нийтийн топ ишлэл”

Б.Чинхороо

ОНЦЛОХ ХУУДАС

Speak out

МОД ТАРЬЖ, БУЯН УЙЛДЭЖ ЧАДСАН УУ

З.МОНХСУВД

Аливаа улсын нийслэлийн 90 хувь олон улсын стандарт байдаг юм байна. Гэтэл манай улсын нийслэл Улаанбаатар хотын срдээ тавхан хувь нь ногоон байгууламж байдал гэсэн харамсалтай тоо бий. Утгаа бол ногоон байгууламжийн хот суурин газрын оршин сүгчдүн тоо, түүний шилжилт хөдөлгөөн, цаашидын осолтойн хандлага, гудамж замын хөдөлгөөн зэрэг олон хүчин зүйлийг харгалзан хариулсан ашиглүүр хэмжээ антиллаар тодорхой төлөвлөгөөний дагуу байгуулдаг. Харин “Азийн цагаан дагина” хэмээн нэрлэгдэж байсан Улаанбаатар хотод маань ногоон байгууламж бараг л байхгүй. Байгаа жаахан ногоон байгууламж дээр нь том машинтэй хүмүүс тоо ч угүй машин тэргээ тавьчихдаг. Адаглаад л “Нэг мод таривал энэ наасны буян, хоёр мод таривал хойд наасны буян” гэж ярьдаг шүү дээ. Тиймээс “Монголын мэдээ” сонин энэ удаагийн “Speak out” булангаараа иргэдийн байр суурийн хүргэж байна.



Гэрэл зурагийг Г.АРГУУЖИН

Н.Баасанхүү: Нэг давхар байшинтай тэнцэхүйц болчихсон байсан шүү дээ

/Сонгинохайрхан дүүргийн иргэн/

-Ээж маань модих тарьдаг хүн байсан юм. Ээжийнхээ ачаар би ч гэсэн мод тарих дуртай болсон. Ер нь аливаа зүйлийг өөрийнхөө сонирхлоор хийнэ гэдэг үзүүлээр сайхан. Жилдээ ер нь нэг мод тарьж, арчлахыг хичээдэг. Тэгэхдээ орон суулгыгээр хотын хөгжил, ногоон байгууламжид хувь нэмэрээ оруулахын тулд чадах чинээгэрээ лаяндхамрагдахыг хичээдэг. Ер нь модын намрын улиралд таривал илүү сайн байдал гэсэн. Гэхдээ хамгийн анх хавар цагт изг жижигхэн мод тарьж байсан. Тэр маань нэлээд том болчихсон бүүр нэг давхар байшинтай тэнцэхүйц болчихсон байсан шүү дээ.

Н.Нансалмаа: Нэлээд хэдэн мод тарьж л байлаа

/Чингэлтэй дүүргийн иргэн/

-Би оөрөө багш мэргжилтэй. Насаараа сургуульд олон хүүхдүүд дунд бужигнаж отөлсөн. Манай тогсгүйтгэхэн ч их мод тарьдаг байсан. Хавар болохоор л мод суулгана, моддоо усална гээд л хөдөлгөөнд ордог. Ер нь сургууль болгон л тэгдэг байх. Хавар боломгц хашаа талбайгаа зүлэгжүүлэх, моджуулах ажлуудыг эрчимжүүлдэг. Бас тэр ажлуудаа багш, сурагчдыг ихээхэн татан оролцуулдаг байсан. Тэр ч утгаараа нэлээд хэдэн мод тарьж байлаа. Түүнээс гадна хувиараа ч гэсэн нэлээдгүй мод тарьж л явлаа. Одоо хөгшрөөд мод тарих нь багассан. Багассан ч гэж ер нь тарихгүй байгаа. Ямар ч байсан залуу байхдаа нэлээд идэвхтэй байсан.



/Баянгол дүүргийн иргэн/

-Би чамлахааргүй олон мод тарьж байсан. Хамгийн анх арван жилдээ мод тарьж эхэлсэн. Ерөнхий боловсролын сургуулиуд чинь сургууль төгсөөхөр төгсөх ангийнхан нийлж байгаад нэлээд олон мод урслуулдэг. Түүний жишгээр л анх тарьж байлаа. Харин одоо өөрийн санаачилгаар клуубуудад нэгдээд хөдөө, хээр, хот гэдэг хаягийн тэрэлжүүлэх гэдэг нь манай улсын хувь маш их хэрэгтэй зүйл л дээ. Хэт хуурай, шире тоос ихтэй нөхцөлдхамгийн зөв арга нь ногоон байгууламжийг цогцоюу юм шүү. Би хоёр зээтэй. Тэд маань жаахан тул улам л цэвэр агаар, шире, тоосгүй орчин хэрэгтэй. Тийм болохоор ах нь аль болох цэцэг навчнаас эхлээд л тарьж болох бүхий л зүйлийг тариалахыг хичээдэг. Нэг зүйл хэлэхэд, мод тарих гэж байгаа бол намрын цагт хүйтгэтийг уралдаад л тарьдаг юм шүү. Нэг ёсondoо унтаа байхад нь суулгадаг гэсэн юг.

С.Ганболд: Энэ жилдээ багтаагаад гурван мод тарина гэж бодож байгаа

/Сонгинохайрхан дүүргийн иргэн/

-Би Сэлэнгийн Зүүнхараагийн хүн л дээ. Нэг ёсondoо хөдоонийг гэсэн уг. Хотод тарьсан ногооноо борлуулах гэж орж ирсэн. Гэхдээ ногоо тариалахынхаа хажуугаар давхар моттарьдаг. Аав, ээж, ах, дүү нар маань бүгд хашаандаа мод тарьдаг.Өөрсдөө ч их дуртай байдал шүү. Их олон жаахан хүүхдүүдийтэй болохоор тэднийгээ ч бас мод хэрхэн тарих вэ. Байгаль орчноо хэрхэн хамгаалах вэ гээд л олон зүйлд сургадаг. Наад зах нь жилийн дөрвөн улирлын хэдийд нь мод тарих ёстой вэ гэдгийг манай хүүхдүүдийн хэн нь ч ялагдагүй маш сайн мэддэг. Намар дохөд л иржээр ээж хэдийд моддоо тарих вэ гээд л асуугаад байдал. Тэгэхээр нь би ч их дуртай тарьдаг шүү. Мод тарьснаар дан ганц цаг, зав нь болохгүй байгаа болохоор мод тарьж чадахгүй л байна.

Ж.Отгонцээг: Хотод ногоон орчин байгуульяа гээд аян зохиовол би үнэ төлбөргүй үрсэлгээний мод бэлэглэнэ

/Сүхбаатар дүүргийн иргэн/

-Боломж нь олдвол мод тарихыг л бодно доо. Энэ чинь сайн үйлсийн нэг шүү дээ. Харин Улаанбаатар хотод тарьсан модын ихэнх нь арчилгаа дутагдсандаа ч юм уу, эсвэл хүмүүсийн буруутай уйлдэлэс болоод ч юм уу хавар тарьсан нь намар үхчих тохиолдол асар их байдал. Үүн дээр анхаарч ажиллавал эзгээр байх. Магадгүй ажилгүй иргэдийг хотын ногоон байгууламжийг арчлах цагийн ажилд авах гэх мэт үйл ажиллагаа зохион байгуулбал аль аль талдаа ашигтай юм шиг санагддаг.

Д.Мөнхтулга: Энэ чинь сайн үйлсийн нэг шүү дээ

/Хан-Үүд дүүргийн иргэн/

-Мод тарих нь эко орчин бүрдүүлэхэд ашигтай гэж боддог. Манай зуслангийн хашаа тэр чигтээ л модтой. Намайг жаахан байхаас л ава, ээж маань зусланц гараахаараа мод, жимс тарьдаг байсан. Одоо ч тарьж байгаа.Өнгөрсөн зүйл л таван мод суулгасан. Түүрүү долоо хоногт очижүзэхэд эхэлээд хөөрхөн том болчихсон юм шиг санагдсан. Гэхдээ мод бүр янз бүрийн үйлчилгээтийг байдал юм байна билээ. Хар мод агаар цэвэршүүлэхэд илүү сайн гэсэн болохоор өнгөрсөн жилийн тарьсан мөддөн дандaa хар мод байсан.Хүмүүс мод тарих хэцүү л гэж боддог. Уг нь нэг тариад дадал болгочихковол их сайхан шүү.

Г.Анхийн: Нэг жилдээ багтаагаад гурван мод тарина гэж бодож байгаа

/Чингэлтэй дүүргийн иргэн/

-Мод тарих, хийд бүтээх, ном бичих гурав чинь хамгийн дээд буяны нэг гэдэг юм байна билээ. Тэгэхдээ ах нь мод тарьж үзээгүй ээ. Залуу байхдаа их олонгийн орчин бий болгоходоо гадна хүүхдийн хумүүжил, төлөвшилт, хайрлах, энэрэх сэтгэлд нь маш их нөлөөлдөг.

ЗАВСАРЛАГА

МОНГОЛ БРЭНД

Н.БАТЗАЯА

Xааяахан гэр бүл, найз шохиодтэйгээ тав тухтай тохилог ресторанд орох гэхээр заавал ч утий Япон, Солонгос, Хятад, Английн сүлжээ ресторанд орж таардаг. Энэ нь ч аргагүй. Нийслэлийн гудамж талбайд тав алхаад л Солонгос, Япон улсын сүлжээ ресторанин ууданд очдог учраас тэр. Үүнээс болж "Яагаад манай улсад ийм их гадаадын сүлжээ ресторан байдаг юм бэ" хэмэн бодож байсан хүн олон биз. Нэг угзэр хэлбэл, манай улсын хоол, хүнсний үйлчилгээний салбарын орон зайн гадаадын сүлжээ ресторанууд эзэлсэн гэдэг нь хэн бүхний нүдэнд илхэн. Тиймээс ч амралтын одроо гэр бүлээрээ ая тухтай өнгөрүүлэх сонирхолтой монгол хүн бүр үндэсний сүлжээ ресторанин эрэлхийдэг гэхэд хэн ч маргаагүй биз ээ. Тэгвэл ард түмнийхээ энэхүү хүсэлд нийцүүзэн "MANDU HOUSE" нэртэй Монголын анхны сүлжээ



Гэрэл зурагий Г.АРГУУЖИН

Монгол брэнд "MANDU HOUSE"-д зоглоорой

ресторан очигдэр нээлтээ хийлээ.

Энэхүү ресторанин байгуулалт төсөл нэг жилийн омно эхэлсэн богое анхны салбараа эх орондоо нээж байгаа нь энэ. Монголын нэрийг дэлхийд гаргах үндэсний сүлжээ ресторанин нээлтэд "Сээзэн пресс" компанийн захирал М.Бодл, Шадар сайдны Ажлын албаны дарга н.Энх-Амгалан, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дэд дарга С.Даваасурэн, "Манду Хаус" компанийн гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагч П.Мөнхчулуун болон "Хар сарнай" хамтлагийн дуучин Амраа, "Мотив" хамтлаг, дуучин А cool зэрэг уран бүтээгдэг оролцлоо. Үндэсний сүлжээ ресторанин нээж, "Манду Хаус" компанийн гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагч П.Мөнхчулуун "Монголын үндэсний үйлчилгээний хамгийн анхны брэнд оноөдөр нээгдээ. Дтоодын зах зээлдийг гадаадын франчайзингийн зах зээлээс хамгаалах, гадаадын зах зээлд

үндэсний брэндийг гаргах зорилгоор энэхүү төслийг анх эхлүүлсэн түүхтэй. Бидний төсөл нэг жилийн хугацаанд үргэлжилж, энэ одор албан ёсоор нээлтээ хийж байгаад байртай байна.

Манай брэнд дотоодын аж ахуйн нэгжийн бүх бүтээгдэхүүнийг үнийн дундээ шингээж өгснөөр давуу талтай юм. Нэг угзэр хэлбл, 100 хувь дотоодын бүтээгдэхүүнийг ашиглана гэсэн уг. Манай нэрийн хоолонд орж буй гурил, мах, давс, амтлагч гээд бүх материалыг дотоодын аж ахуйн нэгж ханган нийлүүлж байгаа. Энэ брэнд гадаадын зах зээлд амжилттай байвал дотоодод үйлдвэрлэсэн "Алтан тария" гурил, "Мах маркет" компанийн мах болон Увс аймгийн нэрийн давс зэрэг үндэсний олон компанийн гадны зах зээлд бүтээгдэхүүнээс амжилттай байршуулж чадах юм" гэв. Мон энэ үеэр тоослын санаачлагчид "Манду хаус" сүлжээ ресторанин Азийн уламжлалт хоолыг орчин үеийн үйлчилгээний стандартад нийцүүлэн гаргаж, дэлхий нийтэд санал болгох буй Монголын үйлчилгээний брэнд юм. "Манду Хаус" брэнд Монгол Улсад боловсруулсан мах, гурил, давс, хүнсний ногоо зэрэг органик түүхий эдийг ашиглан Азийн



уламжлалт

хоолыг өөрийн кофе шопын загвартаар хослуулан орчин үеийн хэв маяг, үйлчилгээ стандартад нийцүүлэн гаргасан үйлчилгээний брэнд аж. Тус төслийг хэрэгжүүлэхийн тулд нэг

жилийн хугацаанд хэрэглэгчдийн дунд судалгаа хийжээ. Мон тэд цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэн Монгол Улсад 10 орчим салбар байгуулахаар төловлюж байгаа гэнэ. Монгол ирэх зургадугаар сард Казахстан болон Овөрモンголд суджээ ресторанин салбараат байгуулах талаар судалж байгаад аж. Монголын брэнд "Манду Хаус" сүлжээ ресторанд зочилсноор таван торлийн бузуу, 12 торлийн хачир, татамд гурвалтай шол, 30-40 торлийн кофе, 12 торлийн десерт, шэйк, латтенаас сонгон үйлчлүүлэх боломжтой. Тодруулбал, 5500 төгрөгийн сетэд нь таван бууз, турван хачир, ясны шөл багтхаасаа гадна ногоон цай болон пепси ундаанаас сонгон авах боломжтой аж. Даширамд сонирхуулахад, "MANDU HOUSE" түргэн хоолын сүлжээ ресторанин үүсгэн байгуулагчид Дэлхийн топ 500 франчайзинг брэндийн жагсаалтад багтаж зорилго тавин ажиллаж байна.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 8
Шоно 1
Нөгөөдөр
Өдөр 3
Шоно 5

Өдрийн зурхай

ХАВРЫН ДУНД
ХАРАГЧИН ТУУЛ САР
ТАВАН ШАР МЭНГЭТГЙ
ЦАГААН БАР ӨДӨР

Наран ургах шингэх: 05.31-20.07
Үс засуулбал: Нас уртаснаа



Тухайн одбор гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтийн аливаа үйлийг хийхэд зөрж сайн ба тогий, тарь жилтийн сорог түү нөлөөтэй тул эндээ үйл хянамгай хандаж, биеэ эхиржүүцүүтэй. Эл одбор насны хүч дэлгэрэн. Эт найруулах, угаал үйлэх, бар авах, насны авшиг, насны бүтээг хийж зан тийл хийгээд төрөл садан болоцох, бурханы ёс ба тарни бүтээх, худалдаа найлааны үйлээ сайн. Баруун чих хангивал асфадах, зүн нь бол буян афвижих, нохой уливал гэрийн тэнгэр ялласан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирж, бие татваал гаслан болох, хөл татваал хувцас олдоно. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, ногой, хөнө, нохой болой.

БИДЭНД ТОХИОЛДСОН



ХҮНДКЭН ХӨГТЭИ ЯВДЛУУД

Nandin Naran

Ах өнгөрсон жил хадамд эгчтэйгээ Америк сансан юм. Эгч нь анх удаа хилийн дээс алхаж байгаа. Тэгээд Соулд буутал ахыг өмнө нь Солонгост харлаж байсан юм байна гээд тэднийг өөр өөр газарт хорьжээ. Ах хадамдаа шоножин санаа зовоод, маргааш нь дараагийн нислэгийн цаг ч болж, ногөө хоёр сулгаджээ. Ах "Та зүгээр үү. Надаас болоод л хоригдчилж" гээтэй эгч нь Хоригдсон юм уу. Би буудал юм байх гэж бодсон" эсэн гэдэг. Хэ эх хэ.



"Met gala"-ын хамгийн эмгээд ба хамгийн задгай гоёл

Б.Даваа

Холливудын хамгийн том хувцас загварын шоу гэж хэлж болохуйц хандивын "Met Gala" наадам болжээ. "Costume Institute Gala" буюу "Met Ball" нэрээр олон нийтэд танил болсон уг ёслолын арга хэмжээ нь "Metropolitan Museum of Art's Costume Institute" музеийн санхүүжилтад зориулан жил бүр

зохион байгуулагддаг юм. Уг наадамд урлаг соёлын алдартнууд оролцон хандив өргөхийн зэрэгцээ өмссөн зүүснээрээ ч уралддаг.

Тэгвэл энэ жилийн наадмын тухайдуучин Рианна, загваромсгч Кендалл Женнер нар бусдаасаа илүүтэйгээр олны анхаарал татсан байна. Тодруулбал, Рианна цэцэгийн дэлбээ бүхий цацган чимэглэлтэй даашинаар гоёж ирсэн нь энэ

үдийн хамгийн овөрмоц гоёл болж чаджээ. Тэрбээр өмнө ч гэсэн онцлог, овөрмоц даашинаа өмч, "Met Gala"-г чимж байсан удаатай. Харин Кендалл Женнер энэ удаагийн наадмын хамгийн задгай даашинаар гоёсон байв. Тэрбээр нэйт гэрэлтдэг, энгэр, хөл ил гарсан уналттай хар даашинаа өмч ирсэн нь зочдиг гайхшируулаад амжсан гэнэ.

THE FATE OF THE FURIOUS
APRIL 14

Нэгэн эмэгтэй Дом-г хүчээр гэмт хэрэгт татан оролцуулж хамгийн дотно хүмүүсийн нь эсрэг ажиллуулна. Гэр бүл шиг болсон тэд урьд өмнө учирч байгаагүй сорилтой тулгарна.

GHOST IN THE SHELL

Аймшигтай ослоос амь гарсан бүсгүй төгс чадвартай кийborg болгон өөрчилж компьютерийн хакеруудын бүлэглэлийн эсрэг илгээн.

TENGIS
Хөнгөлжүүлэх
Тасалбарын үнэ
Магмар, Извест, Нууц төрөл
2000 тог
Бусад ширүүдэл
3000 тог

ТЭНГИС ХӨНГӨЛЖҮҮЛЭХ КАРТ
ТЭНГИС ХӨНГӨЛЖҮҮЛЭХ КАРТ
Хөнгөлжүүлэх
Тасалбарын үнэ
Магмар, Извест, Нууц төрөл
2000 тог
Бусад ширүүдэл
3000 тог

ТЭНГИС ХӨНГӨЛЖҮҮЛЭХ КАРТ
ТЭНГИС ХӨНГӨЛЖҮҮЛЭХ КАРТ
Хөнгөлжүүлэх
Тасалбарын үнэ
Магмар, Извест, Нууц төрөл
2000 тог
Бусад ширүүдэл
3000 тог

ТЭНГИС ХӨНГӨЛЖҮҮЛЭХ КАРТ
ТЭНГИС ХӨНГӨЛЖҮҮЛЭХ КАРТ
Хөнгөлжүүлэх
Тасалбарын үнэ
Магмар, Извест, Нууц төрөл
2000 тог
Бусад ширүүдэл
3000 тог